



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/293

Улаанбаатар хот

“Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл,
үйлчилгээний ажлыг дүгнэх журам”-д
нэмэлт оруулах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.7 дахь заалт, тус газрын Арга зүйн зөвлөлийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/257 дугаартай тушаалаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг дүгнэх журам”-д “Цаг уур, уур амьсгалын мэдээ, мэдээллээр үйлчлэх ажлыг дүгнэх” хэсгийг хавсралтаар нэмсүгэй.

2. Энэ тушаалыг 2024 оны ажил дүгнэх үйл ажиллагаанаас эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ОЮУНЖАРГАЛ

151240852

d:\2024\а тушаал\11.05-293.docx



ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ҮЙЛЧЛЭХ АЖЛЫГ ДҮГНЭХ

Цаг уур, уур амьсгалын мэдээ, мэдээллээр үйлчлэх үйлчилгээний ажлыг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- Мэдээллээр үйлчлэх ажлыг /нислэгийн цаг агаарын мэдээ орохгүй/ улс, аймаг, хот, сум дүүргийн түвшинд тус тусад нь дүгнэнэ.
- Улсын түвшинд ЦУОШГ, түүний харьяа байгууллагуудын мэдээлэл, үйлчилгээний ажлын дүнг жилийн эцэст нэгтгэн гаргана.
- Аймаг, хотын мэдээлэл, үйлчилгээний ажлыг хариуцаж буй нэгж нь сум, дүүргийн өртөө, харуулын мэдээлэл, үйлчилгээний ажлыг сар бүрээр дүгнэж, жилийн эцэст нэгтгэн ЦУОШГ-т тайлагнана.
- Сум, дүүргийн түвшинд цаг уурын өртөө, харуул нь өөрийн мэдээлэл, үйлчилгээний тайланг сар бүр гаргаж, Аймаг, хотын УЦУОШТ-дөө тайлагнана. Үйлчилгээний ажлын тайланд орчин үеийн харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл ашигласан, цаасан болон цахим сүлжээгээр хүргэсэн талаараа баримтыг хавсаргана.
- Аймаг, хотын Урьдчилан мэдээлэх нэгжийн заавал гаргах урьдчилсан мэдээний төрөл, тоог газрын Урьдчилан мэдээлэх асуудал хариуцсан нэгж, Уур амьсгалын мэдээний нэр төрлийг Цаг уурын асуудал хариуцсан нэгж тогтоож өгөх ба төв, орон нутагт зориулан гаргах мэдээ, тусгай хэрэгцээний урьдчилсан болон горимын мэдээг хэрэглэгчийн эрэлтээр гаргаж үйлчилнэ.
- Сум, дүүргийн үйлчлэх мэдээний төрөл, тоо, үйлчилгээнд хэрэглэх сувгийн хэлбэр, тоног төхөөрөмжийг Аймаг, хотын УЦУОШТ тогтоож өгөх ба үйлчилгээг улам бүр өргөжүүлэх чиглэл, хөгжүүлэх бодлого барьж ажиллана.

Мэдээллээр үйлчлэх ажлыг дараах 5 үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

- Тайлангийн ирц
- Үйлчилгээний тогтмолжилт /хувь/, мэдээний төрөл, тоогоор
- Үйлчилгээний хүрээ /хувь/, үйлчлэх хэрэглэгчийн төрөл, сувгийн тоогоор
- Аюултай Үзэгдэл /АҮ/, Байгалийн гамшигт үзэгдэл /БГҮ/-ээс сэрэмжлүүлж чадсан эсэх /хувь/, сэрэмжлүүлсэн хувиар
- Тусгай хэрэгцээний урьдчилсан болон горимын мэдээний төрөл, хэрэглэгчийн тоо

1. Тайлангийн ирц

Тайлангийн ирцийг хувиар дүгнэх ба тайланг цахим хэлбэрээр Сум, дүүргийн өртөө, харуулаас Аймаг, хотын мэдээлэл, үйлчилгээний ажлыг хариуцаж буй нэгжид сар бүрийн 05-ны дотор ирүүлэх ба хоцорсон хоног тутамд 1 хувь хасаж тооцно. 05-ны өдөр амралтын өдөр таарсан үед дараагийн ажлын өдрөөр тооцож авч байна.

2. Үйлчилгээний тогтмолжилт /хувь/

Үйлчилсэн мэдээний төрөл ба тоог хувиар /%/ гаргана. Хэдэн төрлийн мэдээгээр хэдэн удаа үйлчилсэн дундаж хувь.

$$S_s = \frac{1}{2} \left(\frac{k}{K} 100\% + \sum_{i=1}^{i=k} \frac{n_i}{N_i} 100\% \right);$$

Энд,

S_s – мэдээллээр үйлчлэх ажлын тогтмолжилт

K – сард үйлчлэх нийт мэдээний төрөл, k сард үйлчилсэн мэдээний төрөл

N_i – нийт үйлчлэх мэдээний тоо, n_i – сард үйлчилсэн мэдээний тоо

Мэдээний төрөл гэдэгт: 1-5 хоногийн, 7 хоногийн, сарын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, УСМ, бодит мэдээ, бэлчээрийн даац, багтаамжийн мэдээ, хортон, шавж, ургамлын ургалтын байдал, орчны хяналт шинжилгээний мэдээ, агаарын бохирдол, усны чанар, гол, нуурын урсац, усны түвшний мэдээ ... г.м байсан бол $K=7$, үүнээс бүгдээр нь үйлчилсэн бол $k=7$ болно. Тоо гэдэгт сард тухайн төрлийн мэдээгээр хэчнээн удаа үйлчлэх тоо орно. Жишээ нь: 1-5 хоног 30, 7 хоног 4, сарын мэдээ 1, сэрэмжлүүлэг 3, УСМ 1, бодит мэдээ 30, бэлчээрийн даац, багтаамжийн мэдээ 1 байсан гэвэл $N=70$, үүнээс 1-5 хоног 28, 7 хоног 4, сарын мэдээ 1, сэрэмжлүүлэг 2, УСМ 1, бодит мэдээ 28, бэлчээрийн даац, багтаамжийн мэдээ 1-ээр үйлчилсэн гэвэл $n=65$ болно.

Зөв бодолт: Хаалтан доторх хоёрдугаар гишүүн k тооны нийлбэрээс бүрдэнэ.

$$S_s = \frac{1}{2} \left(\frac{7}{7} 100\% + \left(\frac{28}{30} + \frac{4}{4} + \frac{1}{1} + \frac{2}{3} + \frac{1}{1} + \frac{28}{30} + \frac{1}{1} \right) 100\% \right) = \frac{1}{2} (100\% + 93.32\%) = 96.66\% \approx 96.7\%$$

Буруу бодолт:

$$S_s = \frac{1}{2} \left(\frac{7}{7} 100\% + \frac{65}{70} 100\% \right) = 96.4\%$$

Үйлчилсэн мэдээний төрөл тус бүрд нь хувь гаргаагүйгээс үнэлгээ буурсан.

3. Үйлчилгээний хүрээ

Үйлчилгээний хүрээг үйлчлэх хэрэглэгчийн төрөл ба сувгийн тоогоор дүгнэнэ. Хэчнээн төрлийн хэрэглэгчдэд, хэчнээн төрлийн сувгаар тасралтгүй үйлчилж байгааг энэ үзүүлэлт харуулна.

Үйлчлэх хэрэглэгчийн төрөлд төрийн байгууллага, ард иргэд, тусгай хэрэгцээний мэдээ авдаг компани, аж ахуйн нэгж, цахим сайтуудын хандалт, дагагчдын тоо оруулан тооцно.

Мэдээлэл хүргэх сувагт биеэр танилцуулах, ТВ, Радио, самбар, интернэт, цахим сүлжээ (Facebook, Instagram, X г.м) мобайл г.м орно.

$$S_{fw} = \frac{1}{2} \left(\frac{us}{US} 100\% + \frac{ch}{CH} 100\% \right);$$

Энд: S_{fw} – үйлчилгээний хүрээ. Үйлчилгээ үзүүлж буй цар хүрээ – *service framework*

US – нийт үйлчлэх хэрэглэгчийн төрөл, us – сард үйлчилсэн хэрэглэгчийн төрөл

CH – үйлчилгээний нийт сувгийн тоо, ch – сард үйлчилгээнд ашигласан сувгийн тоо

Жишээ нь, Төрийн байгууллага 3 /Засаг дарга, ЗДТГ, Онцгой байдал/, баг 5, аж ахуйн нэгж 3, хувиараа эрхлэгч 4, малчин 1-д үйлчилдэг гэвэл $US=16$ болно. Хэрэв 1 аж ахуйн нэгж, хувиараа эрхлэгч 1 хүнд үйлчлээгүй гэвэл $US=14$ болно. Мэдээлэл хүргэх сувагт ТВ-2, Радио 1, самбар 2, интернэт 1 Веб сайт, мобайл 3 байдаг гэвэл $CH=9$, үүнээс 1 мобайлд мэдээлэл өгч амжаагүй гэвэл $CH=8$ болно. Тэгвэл,

$$Sfw = \frac{1}{2} \left(\frac{14}{16} 100\% + \frac{8}{9} 100\% \right) = \frac{87.5 + 88.9}{2} = 88.2\%$$

4. АҮ, БГҮ-ээс сэрэмжлүүлсэн байдал

Нийт болсон АҮ, БГҮ-ийн хэдэд нь сэрэмжлүүлэх ба урьдчилан сэргийлэх мэдээгээр үйлчилснийг хувилж гаргана.

$$Ser = \frac{n_{us}}{N_{\Sigma}} 100\%$$

Энд, Ser — АҮ, БГҮ-ээс сэрэмжлүүлсэн байдал, хувь

N_{Σ} — нийт ажиглагдсан АҮ ба БГҮ-ийн тоо буюу зарласан мэдээний тоо

n_{us} — тухайн сард СМ, УСМ-ээр үйлчилсэн, сэрэмжлүүлсэн АҮ, БГҮ-ийн тоо

5. Тусгай хэрэгцээний урьдчилсан болон горимын мэдээгээр үйлчилсэн байдал

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 3.1.6 заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/298 дугаар тушаал “Ус, цаг уурын тусгай хэрэгцээний урьдчилсан болон горимын мэдээний нэр төрөл, үйлчилгээний үнэ тариф батлах тухай”, Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/68 дугаар тушаал “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох тухай тушаалын гуравдугаар хавсралтаар тус тус ус цаг уур, орчны бүхий л төрлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн байдал, мэдээний нэр төрөл, хэрэглэгчийн тоон мэдээлэл байна.

---oOo---